


## 2. Эцэг эхийн системд бүртгүүлэх заавар

### Эцэг эхийн системд бүртгүүлэх


Эцэг эх системд бүртгүүлсэнээр өөрийн хүүхдийн хичээлийн хуваарь, дүн үнэлгээ, ирц, чөлөө авах, хичээлийн жилд судалж байгаа хичээлүүд зэрэг мэдээллүүдийг харах боломжтой.

Шинээр хэрэглэгч үүсгэхэд дараах алхамчилсан зааврын дагуу бүртгүүлнэ.

1. <https://parent.edu.mn/login> эцэг эхийн систем рүү нэвтрэн орно.



2. Эцэг эхийн системд шинээр бүртгэл үүсгэхэд баруун дээд хэсэгт байрлах **БҮРТГҮҮЛЭХ** гэсэн товч руу нэвтрэн орно.




3. Бүртгүүлэх цэсийг дарахад дараах цонх гарч ирэх бөгөөд талбарт өгөгдсөн утгуудыг бөглөж **ҮРГЭЛЖЛҮҮЛЭХ** товч дээр дарна.

а. **Имэйл хаяг:** Эцэг/эх өөрийн имэйл хаягаа оруулна. /Имэйл хаягаар баталгаажуулах код очих тул баталгаат имэйл хаягаа ашиглах/

б. **Утасны дугаар:** Өөрийн утасны дугаарыг бичнэ.

в. **Нууц үг:** Заавал том үсэг агуулсан байх, заавал тоо оруулсан байх, багадаа нэг тусгай тэмдэгт агуулсан байх, 8 тэмдэгт агуулсан байх шаардлагатай.



4. Бүртгүүлсэн и-мэйл хаяг эсвэл утасны дугаарт хэрэглэгчийн эрхийг баталгаажуулах код очно.

а. **Хэрэглэгчийн эрхийг баталгаажуулах код:** Тухайн кодыг хуулбарлан, хэрэглэгчийн бүртгэл

баталгаажуулалтанд ашиглана.

< BACK TO LIST

Delete Source



esisnoreply@edu.mn

Date:

15-09-2021 08:55:12

Subject: Хэрэглэгчийн баталгаажуулалт

**Шинэ хэрэглэгчийн баталгаажуулалт**

Эрхэм хэрэглэгч танд энэ өдрийн мэнд хүргэе.

Та Боловсролын салбарын мэдээллийн системд хэрэглэгчээр бүртгэгдэх хүсэлт илгээсэн байна.

Та имэйл хүлээж авсанаас хойш 24 цагийн дотор доорхи кодоор баталгаажуулна уу.

**694661**

Танд баярлалаа.

Бидэнтэй холбоо барих:

Вэб сайт: <https://parent.edu.mn>

Имэйл: [info@edu.mn](mailto:info@edu.mn)

8:58



< 138080



Add to contacts

Block number

Wednesday, 15 September 2021



[parent.edu.mn](https://parent.edu.mn) - tani batalgajuulah kod:  
[538387](https://parent.edu.mn)

8:58 am



5. **Үргэжлүүлэх товч** дарж шинэ хэрэглэгчийн бүртгэл талбарын дараах утгуудыг бөглөнө.

\* **Регистрийн дугаар** /эцэг эх, асран хамгаалагч/

\* **Овог нэр** /эцэг эх, асран хамгаалагч/

\* **Баталгаажуулах код** /Утасны дугаар эсвэл имэйл хаягт ирсэн баталгаажуулах код/